

Гуравдагч этгээдийн ёс зүйн дүрэм /глобал/

2020 оны 2 сар



pwc

Агуулга

1

Оршил

Тодорхойлолтууд	2
Санал бодлоо илэрхийлэх	3
Энэхүү Дүрэм,хууль,тогтоомжууд дагаж мөрдөх	3
Нягтлан баталгаажуулах,хянах	3

4

Хийж буй бизнестээ итгэлцэл бий болгох

Хараат бус байдал	4
Ашиг сонирхлын зөрчил, ээдрээтэй нөхцөл байдал	4
Шударга өрсөлдөөн	5
Авилгатай тэмцэх	5
Эдийн засгийн гэмт хэрэг,мөнгө угаах	6
Дотоод мэдээллийн худалдаа	6
Хориглох арга хэмжээ, экспортын хяналт	6

7

Харилцан итгэлцэл бий болгох

Ажилд авах,хөдөлмөрийн харилцаа	7
Цалин хөлс, ажлын цаг	7
Ажилтнуудтай харилцах Гуравдагч этгээдийн харилцаа	8
Хүүхдийн хөдөлмөр	8
Хүний наймаа, орчин үеийн боолчлол	8
Эрүүл мэнд аюулгүй байдал	8

9

Олон нийтийн дунд итгэлцэл бий болгох

Байгаль орчныг хамгаалах	9
--------------------------	---

10

Мэдээлэл ашиглахдаа итгэлцэл бий болгох

Нууцлал,хувийн мэдээллийг хамгаалах	10
Оюуны өмч	10
Мэдээллийн технологийн аюулгүй байдал	10
Нийгмийн сүлжээ	11

11

Дүрмийг хүлээн зөвшөөрөх

Танилцуулга

PwC нь дэлхийн нэр хүндтэй байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг дэлхийд тэргүүлэгч байгууллага юм. PwC-ийн зорилго нь нийгэмд итгэлцлийг бий болгож, тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх.

PwC нь ёс зүйн болон мэргэжлийн стандарт, хууль тогтоомж, зохицуулалт, дотоод бодлого болон дараах үндсэн үнэт зүйлсийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна:



Шударга байх

- Зөв зүйлийн төлөө санал, бодлоо илэрхийлэх, ялангуяа төвөгтэй, хэцүү санагдсан үед
- Аливааг хамгийн өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүн гаргаж бусдаас мөн ийм үр дүн хүлээх
- Ажлаа хийхдээ өөрсдийн хувийн нэр хүнд хөндөгдөх мэт ажиллаж, шийдвэр гаргах



Өөрчлөлт хийх

- Амьдарч буй эх дэлхийнхээ ирээдүйн талаар мэдээлэлтэй байх, асуулт тавьж анхаарал хандуулах
- Үйл ажиллагаагаараа дамжуулан хамт ажиллагсад, үйлчлүүлэгчид цаашлаад нийгэмд үр нөлөө үзүүлэх
- Байнга хувьсан өөрчлөгдөж буй орчинд зохицон ажиллах



Халамжлах

- Хувь хүн бүрийг ойлгох, тэдэнд юу чухал болохыг мэдэхийг хичээх
- Хүн бүрийн оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх
- Бусдыг хөгжиж дэвших, үр дүнтэй ажиллахыг нь дэмжих



Хамтран ажиллах

- Өөрсдийн харилцаа холбоо, санаа бодол, мэдлэг мэдээллийг бусадтай харамгүй хуваалцах, хамтрах
- Янз бүрийн үзэл бодолтой хүмүүс, хандлагыг эрж хайн нэгтгэх
- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх зорилгоор бусдын саналыг сонсох, бусад санал бодлоо хэлэх



Боломжийг бүрдүүлэх

- Шинэ зүйл туршиж, тогтсон аргачлал, ойлголтод автахгүй, шинэчлэх
- Алдаанаас суралцах, шинийг бүтээх, туршиж үзэх
- Шинэ санаа бүрээс боломж нээх, нээлттэй хандах

РwС нь НҮБ-ын Глобал компакт гэрээнд ("UNGC") нэгдэн орсон бөгөөд тус гэрээний тусгагдсан үндэс суурь 10 зарчмыг баримталдаг. Эдгээр зарчмуудыг энэхүү Дүрэмд тусгасан болно.

РwС-ийн Гуравдагч этгээдийн ёс зүйн дүрэм ("Дүрэм") нь хамтран ажиллаж буй Гуравдагч этгээдээс хүлээгдэж буй шударга байдал, бизнесийн үйл ажиллагаанд мөрдөгдөх үндсэн стандартуудыг тайлбарласан болно. Гуравдагч этгээд нь өөрийн Ажилтнууд болон РwС-тай эсхүл түүнд үйлчилгээ үзүүлэхэд оролцдог бусад байгууллага, хүмүүсээс ижил түвшний шударга үнэнч, ажил хэргийн ёс зүйн шаардлага тавихыг РwС шаарддаг.

Гуравдагч этгээд нь тулгарч болох бүх нөхцөл байдлыг ёс зүйн дүрмээр бүрэн зохицуулах боломжгүй гэдгийг РwС хүлээн зөвшөөрч байна. Иймд энэхүү Дүрэм нь Гуравдагч этгээдийн зүгээс бизнесийн ёс зүйн хэм хэмжээг сахих талаар зөвлөмж авах, тулгарсан асуудлыг зохистой шийдвэрлэх түүний өөрийн үүрэг, хариуцлагыг орлохгүй. Гуравдагч этгээдүүд РwС-д үйлчилгээ үзүүлэхдээ шаардлагатай зааварчилгаа, удирдамжийг энэ асуудлыг хариуцсан РwС-ийн ажилтнуудаас авахыг зөвлөж байна.

Тодорхойлолт

Гуравдагч этгээд/Гуравдагч этгээдүүд

гэж РwС-д бараа, үйлчилгээ нийлүүлж буй албан байгууллагууд (тэдгээрийн Ажилтнууд*) эсхүл хувь хүмүүсийг ойлгоно.

*Ажилтнууд гэж Гуравдагч этгээдүүдийн ажилтнууд, гэрээт ажилтнуудыг ойлгоно.

Санал, бодлоо илэрхийлэх

Бидний стандарт

Партнер/захирал, ажилтнууд зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг үнэн зөвөөр мэдээлснийхээ төлөө аливаа эсэргүүцэлтэй тулгарахгүй байх талаар PwC анхаарч тэднийг хамгаалах үүрэгтэй. Эдгээр зарчмуудыг энэхүү Дүрэмд тусгасан болно.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамааралтай вэ?

PwC-ийн бизнесийн үйл ажиллагаатай (PwC-д бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх гэх мэт) холбогдуулан энэхүү Дүрэм, хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн болон мэргэжлийн стандартууд зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл бий болсон гэж үзвэл Гуравдагч этгээд нь PwC -д мэдээлнэ.

Хууль, тогтоомжоор хориглоогүй бол PwC нь Гуравдагч этгээдээс энэхүү ёс зүйн дүрэмтэй холбоотой гомдол, мэдээллийг дараах сувгуудаар дамжуулан хүлээн авахад бэлэн байна. Тухайлбал:

- Гуравдагч этгээдийн үйлчилгээг хариуцаж буй ажилтнаар дамжуулж;
- PwC-д байгаа холбогдох журмын дагуу;
- PwC-ийн Глобал ёс зүй, Комплаенсийн тусламжийн суваг буюу pwc.com/ethics хаягаар хандана уу.

Мэдээллийг нэрээ нууцлан өгч болно.

PwC-ын зүгээр Гуравдагч этгээд нь өөрсдийн Ажилтнууд, тэдний гомдол, мэдээлэл гаргасан үйлдэлд ямар нэг хариуцлага тооцохгүй талаар мэдэгдэх шаардлагыг тавьдаг.

PwC нь ирсэн гомдол, мэдээллийг хянаж / шалгаж, шаардлагатай тохиолдолд Гуравдагч этгээдийг тухайн асуудлын талаар судалж, шийдвэрлэхийг шаардах болно.

Энэ Дүрэм, хууль бусад эрх зүйн актыг дагаж мөрдөх

Гуравдагч этгээд нь холбогдох дотоодын болон олон улсын хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөх бөгөөд энэхүү Дүрмийг мөн дагаж мөрдөх үүрэгтэй. Энэхүү Дүрмээс давсан шаардлага бүхий аливаа хууль, эрх зүйн зохицуулалт байгаа тохиолдолд тухайн хууль, эрх зүйн актын зохицуулалтыг баримтална.

PwC нь Гуравдагч этгээдээс энэхүү дүрмийг дагаж мөрдөхтэй холбоотой бодлого, журмыг хэрэгжүүлж, шаардлагатай сургалтыг явуулна гэж итгэж байна.

Нягтлан шалгах ба мониторинг хяналт

Манай стандарт

PwC нь өөрийн дотоод стандартууд, бодлогын хэрэгжилтэд мониторинг хийж, хяналт тавьдаг. Өөрсдийн стандарт, дотоод журмыг чанд дагаж мөрдөх нь PwC-ийн амжилтын чухал хэсэг юм.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамааралтай вэ?

Гуравдагч этгээд нь энэхүү Дүрэмтэй нийцүүлсэн үйл ажиллагааны хяналтын тогтолцоотой байхыг PwC шаарддаг.

Шаардлагатай тохиолдолд PwC нь Гуравдагч этгээдтэй харилцаа, хамтын ажиллагаагаа үнэлэх ажлын хүрээнд Гуравдагч этгээдийн эрсдэлд суурилсан үнэлгээг хийдэг. PwC-аас хүсэлт гаргасан тохиолдолд PwC-ийн хийх хяналт, шинжилгээний ажлыг хөнгөвчлөх үүднээс Гуравдагч этгээд бүрэн, үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.

Хэрэв Гуравдагч этгээд энэ Дүрмийг зөрчсөн гэж үзвэл PwC-ын зүгээс Гуравдагч этгээдээс зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэхийг шаардах, эсхүл онцгой тохиолдолд Гуравдагч этгээдтэй харилцах харилцаагаа түр зогсоох эсхүл цуцалж болно.



Бизнестээ итгэлцэл бий болгох

Бие даасан хараат бус байдал

Бидний стандарт

PwC нарийн зохицуулалттай мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд аудит, баталгаажуулалтын үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдээс хараат бус байхыг шаардсан холбогдох хууль тогтоомж, дотоодын болон олон улсын стандартуудыг дагаж мөрддөг. PwC нь хараат бус, бие даасан байдалд нь заналхийлсэн эсхүл занахийлж болохуйц нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлж, зайлсхийдэг. PwC өөрийн үйлчлүүлэгч, харилцагчиддаа бодитой, шударга ёсны зарчимд нийцсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд ингэж ажиллах нь эргээд бид аудит, баталгаажуулах үйлчилгээ үзүүлэхэд бие даасан хараат бус байдлаа хадгалахад дэмжлэг болдог.

Хараат бус байдал гэдгийг аудит, баталгаажуулах үйлчилгээ үзүүлэх явцад асуудалд бодитой хандахад саад болох аливаа ашиг сонирхол, харилцаанаас гадуур байх явдад гэж PwC тодорхойлдог.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Зарим тохиолдолд Гуравдагч этгээдүүд PwC-ийн бие даасан хараат бус байх зарим зарчмыг дагаж мөрдөх шаардлагатай нөхцөл байдал үүсдэг. Энэ нь тухайн этгээд PwC-тэй ямар харилцаатай вэ гэдгээс шалтгаалах ба үүнд PwC-ийн мэргэжлийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлдэг Гуравдагч этгээдүүд, PwC-тэй хамтран ажилладаг Гуравдагч этгээд зэрэг орно. PwC Гуравдагч этгээдүүдэд тэдгээрийн хүлээх үүргийн талаар мэдэгдэнэ.

PwC-аас шаардсан тохиолдолд бие даасан, хараат бус байдлын зарчмыг Гуравдагч этгээд нь дагаж мөрдөх бөгөөд энэ асуудлаар хүлээх үүргийнх нь талаар Ажилтнууддаа мэдэгдэнэ.

Ашиг сонирхлын зөрчил ба ээдрээтэй байдал

Манай стандартууд

PwC нь үйлчилгээ өгөхөөр зөвшөөрөх, үйлчилгээг эхлүүлэх эсхүл үргэлжлүүлэхээсээ өмнө тухайн үзүүлэх үйлчилгээтэй холбоотой бодитоор бий болсон болон болзошгүй ашиг сонирхлын зөрчил, үүсч болох ээдрээтэй, эрсдэлтэй нөхцөл байдлыг олж илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэхэд анхаардаг.

Ашиг сонирхлын зөрчил гэдгийг PwC-аас үйлчилгээ үзүүлэх эсхүл PwC өөрийн үйл ажиллагааг явуулах явцад PwC-ын зүгээс асуудалд бодитой хандах чадварт нь эргэлзээ төрүүлэх аливаа нөхцөл байдал гэж PwC тодорхойлдог. Ээдрээтэй байдал гэдгийг PwC-ийн ажил хэрэг, нэр хүнд эсхүл түүний үйлчлүүлэгчтэйгээ харилцах харилцаанд ноцтой асуудал үүсгэж болзошгүй нөхцөл байдал гэж PwC тодорхойлдог.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Хэрэв Гуравдагч этгээд өөрийн болон PwC-ийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц ашиг сонирхлын зөрчил, ээдрээтэй байдал бий болсон эсхүл бий болж болзошгүй талаар мэдвэл PwC-д цаг тухайд нь мэдэгдэнэ.

Нөхцөл байдлаас хамааран Гуравдагч этгээд нь ашиг сонирхлын зөрчил эсхүл ээдрээтэй байдлыг зохицуулах талаар зохих арга хэмжээг авахыг шаардлагатай болж болно.

Шударга өрсөлдөөн

Манай стандарт

PwC нь шударга өрсөлдөөнийг тууштай дэмждэг бөгөөд өрсөлдөөнийг хязгаарласан аливаа үйл ажиллагааг ямар ч хэлбэрээр дэмждэггүй.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь дангаараа эсхүл бусад аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй хамтран ажиллах үедээ холбогдох өрсөлдөөний хууль тогтоомж, дүрэм журмаар хориглосон аливаа шударга бус өрсөлдөөнөөс татгалзана. Ялангуяа, Гуравдагч этгээд нь албан эсхүл албан бус байдлаар, хууль бусаар өрсөлдөөн хязгаарлах, үнэ, нөхөн олговор, урамшуулалыг дүнг хэлцэн тогтоох; эсхүл PwC-д холбогдуулан эсхүл түүний өмнөөс үйлчлүүлэгч, зах зээл, хүмүүс, үйлчилгээг хуваарилах зорилгоор аливаа тохиролцоо хийж болохгүй.

Авилга, хээл хахуультай тэмцэх

Манай стандарт

PwC нь авилга, хээл хахуулийг ямар ч хэлбэрээр зөвшөөрөхгүй. Авилга, хээл хахууль өгөх, хүлээн авах, санал болгох, амлах эсхүл бусад зохисгүй төлбөр, хөнгөлөлтийн төлбөрийг шууд болон аль нэг этгээдээр дамжуулан хийхийг хатуу хориглоно.

Авилга гэдгийг үндэслэлгүйгээр төлбөр тооцоо хийх, ажил хэргээ бүтээх, хууль бус/эрүүгийн хэрэг үйлдэх, итгэмжлэгдсэн эрх мэдлээ хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, зохисгүй давуу байдал бий болгох гэж PwC тодорхойлдог. Хээл хахууль гэдэгт хууль бус, ёс зүйгүй, зохисгүй зүйл хийсний, итгэл эвдсэний, хүлээн авагчийн санал дүгнэлт гаргах шийдвэрт нөлөөлөх аливаа зүйл хийснийхээ төлөө урамшуулал, мөнгө, бэлэг, аливаа үнэ өртөгтэй (үүнд: мөнгөн бус үнэ цэнэ, жишээ нь дадлага, сургалт явуулах гэх мэт) зүйлийг санал болгох, амлах, өгөх, хүлээн авах, авах зэргийг хамруулж PwC тодорхойлдог. Харин зуучлалын хөлс гэж одоо ажиллаж байгаа эсхүл өмнө нь ажиллаж байсан төрийн албан хаагчийг үүргээ биелүүлэхэд нь (жишээ нь: зөвшөөрөл, лиценз, виз, илгээмж, ус/дулаан/цахилгаан/хийн хангамж авах ажлыг түргэтгэх гэх мэт) тодорхой хэмжээний бэлэн, бэлэн бус хэлбэрээр мөнгө өгөхийг хэлнэ гэж тодорхойлдог.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд PwC компанитай хамтран эсхүл түүнд үйлчилгээ үзүүлэн ажиллах үедээ ямарваа нэг байдлаар авилга, хээл хахуультай холбогдохгүй, эсхүл холбогдсон мэт харагдуулах үйл ажиллагаанд (зүй бус төлбөр гэх мэт) холбогдохгүй. Үүнд зуучлалын хөлс эсхүл тусгай эрх өгөх, авах зэргээр PwC-д өөрт нь эсхүл түүний өмнөөс хахууль өгсөн гэж ойлголт төрүүлэх зүйлсийг багтаана.

Гуравдагч этгээд нь PwC-аас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр PwC-ийн нэрийн өмнөөс одоо ажиллаж байгаа эсхүл өмнө нь ажиллаж байсан төрийн албан хаагчид, эсхүл худалдаа арилжааны түншүүдэд бэлэг, дурсгалын зүйл өгөхгүй, тэднээс авахгүй байх ёстой.

Эдийн засгийн гэмт хэрэг, мөнгө угаах

Бидний стандарт

PwC нь эдийн засгийн гэмт хэрэг, үүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг үйлдлүүдийг үл тэвчих болно.

Эдийн засгийн гэмт хэрэг гэдгийг санхүүгийн болон эдийн засгийн ашиг олох зорилгоор явуулсан хууль бус үйлдэл гэж PwC тодорхойлдог. Харин мөнгө угаах үйл ажиллагаа гэдгийг хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олсон мэт болгодог үйл явц гэж PwC тодорхойлдог. Үүнд ийм орлогыг нуун дарагдуулах, эзэмших, ашиглах, олж авах үйлдэл эсхүл уг үйлдлийг дэмжсэн үйлдэл хамаарна.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь PwC-ийг эдийн засгийн гэмт хэрэг, түүний дотор мөнгө угаах үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар татан оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх ямар ч үйлчилгээ үзүүлэх эсхүл бусад ажиллагаа хийх ёсгүй. Гуравдагч этгээд нь хууль бус (жишээ нь терроризм, татвараас зугтаах, залилан мэхлэх) үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, дэмжихгүй байх ёстой.

Дотоод мэдээллийн худалдаа

Бидний стандарт

PwC нь дотоодын мэдээллийг худалдаалах, зохисгүйгээр бусдад дэлгэх, задруулахыг зөвшөөрдөггүй.

Дотоод мэдээлэл гэдгийг байгууллагын талаарх (санхүүгийн урьдчилсан тооцоо, нэгдэх болон худалдан авах санал, голлох ажилчдын өөрчлөлт зэрэг) олон нийтэд зарлагдаагүй мэдээлэл гэж PwC тодорхойлдог. Дотоод мэдээлэл зөвхөн PwC-ээс бус өөр бусад эх сурвалжаас гарч болно.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээдүүд нь PwC-тай хамтран ажиллах үедээ олж авсан эсэхээс үл хамааран аливаа дотоод мэдээллийг худалдахгүй, зохисгүй аргаар олж авахгүй, бусдад задруулахгүй, задруулахад оролцохгүй.

Компанийн талаарх дотоод мэдээллийг эзэмшиж байгаа Гуравдагч этгээд нь тухайн компанийн үнэт цаасыг худалдаж авах, эсхүл борлуулах ажиллагаа хийж болохгүй.

Хориг арга хэмжээ ба экспортын хяналт

Бидний стандарт

PwC нь эдийн засгийн хориг арга хэмжээ, экспортын хяналтын хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйл ажиллагаа явуулдаггүй ба бусдад энэ тал дээр аливаа туслалцаа үзүүлдэггүй.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь холбогдох эдийн засгийн хориг арга хэмжээ, экспортын хяналтын хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба тухайн эдийн засгийн хориг, экспортын хяналтын хууль тогтоомжийг зөрчиж, өөрсдийгөө болон PwC-ийг зөрчил гаргасан нөхцөлд оруулах аливаа үйлдлийг хийхээс зайлсхийх хэрэгтэй.



Харилцан итгэлцэл бий болгох

Гуравдагч этгээд нь олон улсын хүний эрхийн тунхаглал, стандартад нийцсэн хөдөлмөрийн нөхцлийг, үүнд Олон улсын хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын ("ОУХБ") Үндсэн Зарчим ба Ажил дээрх эрхийн тунхаглалд тусгагдсан үндсэн эрхийн зарчмыг хангаж ажиллахыг PwC шаарддаг.

Ажилд авах, хөдөлмөрийн харилцаа

Бидний стандарт

PwC нь бүх хүмүүст хөдөлмөр эрхлэх адил тэгш боломжийг олгоход анхаарч ажилладаг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь аливаа хувь хүмүүсийг ажилд авч, ажиллуулахдаа ялгаварлан гадуурхаж болохгүй. Үүнд арьс өнгө, үндэс угсаа, нас, хүйс, үзэл бодол, бэлгийн чиг хандлага, улс төрийн үзэл, иргэний харьяалал, үндэстэн, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, эцэг эх, эдийн засаг/анги давхарга, ахмад дайчны байдал эсхүл тухайн албан тушаалд тавигдах шаардлагад хамаарахгүй бусад зүйлээр ялгаварлан гадуурхах хамаарна.

Цалин хөлс, ажлын цаг

Бидний стандарт

PwC нь цалин хөлс, ажлын цаг, илүү цагаар ажиллуулах асуудлыг зохицуулахдаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь ажлын цаг, цалин хөлс, илүү цагийн цалин хөлсийг тухайн улсад үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу тогтооно.

Гуравдагч этгээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доош цалин хөлс олгохгүй. Илүү цагаар ажиллуулах шаардлагатай тохиолдолд Гуравдагч этгээдийн зүгээс илүү цагийн хэмжээг тогтоохдоо хүмүүнлэг байж, үр бүтээлтэй ажиллах боломжит түвшинг харгалзан шийдвэрлэх ёстой гэсэн шаардлагыг PwC-ын зүгээс тавьдаг.

Гуравдагч этгээдээс Ажилтнуудтай харилцах

Бидний стандарт

PwC нь аюулгүй, алагчлалгүй ажиллах орчныг бүрдүүлэх үүрэгтэй.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол болон бусад зүй бус үйлдлээс ангид байж аливаа бэлгийн болон бусад хэлбэрийн дарамт шахалт, алагчлах, дээрэлхэх зэрэг бусдыг үл хүндэтгэсэн үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй ажиллах орчныг бүрдүүлэх ёстой.

Хүүхдийн хөдөлмөр

Бидний стандарт

PwC нь хүүхдийн хөдөлмөрийн аливаа хэлбэрийг эсэргүүцэж, үл тэвчих болно.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй бөгөөд үйл ажиллагаа эрхэлж буй тухайн улс оронд мөрдөгдөж буй хөдөлмөрийн насны доод шаардлагыг хангасан ажилтныг ажиллуулна.

Хүний наймаа ба орчин үеийн боолчлол

Бидний стандарт

PwC нь хүний наймаа, орчин үеийн боолчлол, хөдөлмөрийн мөлжлөгийн аливаа хэлбэрийг эсэргүүцэж, үл тэвчих болно.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээдүүд хүний наймаа, орчин үеийн боолчлол, үүнд албадлага, боолчлол эсхүл хүчээр ажил хийлгэх зэргээр хөдөлмөрийн мөлжлөг хийхгүй, үүнийг ямар нэг хэлбэрээр дэмжихгүй.

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Бидний стандарт

PwC нь олон улсын хэмжээнд мөрдөгддөг хүний эрхийн тунхаглалын хүрээнд эрүүл, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлдэг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь олон улсад тунхагласан хүний эрхийн зарчимд нийцсэн эрүүл, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлнэ.

Гуравдагч этгээд ажлын байран дээр гарч буй эрүүл мэнд, аюулгүй байдлын осол, аюулыг доод хэмжээнд барьж, холбогдох хариу арга хэмжээг авч, зохих хувийн хамгаалах хэрэгслээр хангах ёстой.

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө

Бидний стандарт

PwC-ийн партнерууд/захирлууд болон ажилтнууд хуулийн хүрээнд тайван замаар өөрсдийн сонгосон байгууллагуудад нэгдэх, үүсгэн байгуулах эрхтэй.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээдүүд нь Ажилтнууддаа хууль ёсны дагуу эвлэлдэн нэгдэж холбоо, байгууллага байгууллах, түүнд элсэхийг зөвшөөрсөн бодлогыг хэрэгжүүлэхийг PwC шаарддаг.



Олон нийтийн итгэлийг олох

Байгаль орчныг хамгаалах

Бидний стандарт

PwC нь байгаль орчинд учруулах шууд болон шууд бус нөлөөллөө багасгаж, өөрийн зүгээс байгаль орчинд ээлтэй байх арга хэмжээг тасралтгүй сайжруулан ажилладаг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

PwC нь Гуравдагч этгээдээс байгууллагынхаа байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, зохицуулахыг шаарддаг. PwC нь хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, байгаль орчны хариуцлага, хог хаягдлыг үр дүнтэй ашиглах, байгалийн нөөцийг үр ашигтайгаар ашиглах санаачлагыг хэрэгжүүлэхийг Гуравдагч этгээдээс шаарддаг.



Мэдээлэл ашиглахдаа итгэлцэл бий болгох

Нууцлал, хувийн мэдээллийг хамгаалах

Бидний стандарт

PwC нь үйлчлүүлэгчид, тэдний партнер/захирлууд, ажилтнууд болон бизнес эрхэлдэг бусад хүмүүсийн мэдээллийн нууцлалыг хадгалдаг. PwC нь хувийн болон бусад нууц мэдээллийг бүх хэлбэрээр хамгаалдаг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь PwC-тай харилцах явцад олж авсан хувийн болон нууц мэдээллийг зөвхөн PwC-ийн зөвшөөрөл, зааварчилгааны хүрээнд, холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу ашиглаж болно.

Гуравдагч этгээд нь хувийн болон нууц мэдээллийг зөвшөөрөлгүй, хууль бусаар ашиглах, задруулах, нэвтрэх, алдах, өөрчлөх, гэмтээх, устгахаас хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

Оюуны өмч

Бидний стандарт

PwC нь өөрийн оюуны өмчийг хамгаалж, бусдын оюуны өмчийн эрхийг хүндэтгэж ажилладаг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээдүүд нь PwC болон бусад этгээдүүдын оюуны өмчийн эрхийг хүндэтгэхийг PwC шаарддаг. Өөрөөр хэлбэл энэ нь Гуравдагч этгээд PwC-тэй холбоотой ажил үйлчилгээ үзүүлэхдээ PwC-ын болон бусдын оюуны өмчийг тухайн эдтгээдийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй байх, зөвшөөрөлгүй програм хангамж, технологийг ашиглахгүй байх шаардлага юм.

Мэдээллийн технологийн аюулгүй байдал

Бидний стандарт

PwC нь мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар бүхий л мэдээллийн биет хэлбэрийг болон мэдээллийн технологийн хөрөнгийг тус тус хамгаалах арга хэмжээг авдаг.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

Гуравдагч этгээд нь PwC болон PwC-ийн үйлчлүүлэгчид болон бусад гуравдагч этгээдээс олж авсан мэдээлэл түүний дотор биет болон электрон хөрөнгийг хадгалах, хамгаалахад PwC-ийн шаардлагыг хангасан аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийгмийн сүлжээ

Бидний стандарт

PwC нь нийгмийн сүлжээг хариуцлагатай ашиглаж, цахим олон нийтийн харилцаанд соёлтой, хүндэтгэлтэй оролцдог.

Гуравдагч этгээдэд хэрхэн хамаарах вэ?

PwC нь Гуравдагч этгээдээс олон нийтийн мэдээллийн платформ дээр бусдыг үл хүндэтгэсэн, мэргэжлийн бус, дарамталсан, гүтгэсэн, ялгаварлан гадуурхсан, хориотой үйлдэл гаргахгүй байхыг шаарддаг. Гуравдагч этгээд нь PwC-ийг төлөөлөхгүй, бөгөөд PwC-ийн зөвшөөрөлгүйгээр PwC-ийн нэрийн өмнөөс эсхүл түүнд хамаатгасан аливаа мэдээлэл өгөхгүй, эдгээртэй холбоотой үзэл бодлоо илэрхийлж болохгүй.

Энэхүү Дүрмийг хүлээн зөвшөөрөх

PwC болон түүний үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллаж буй Гуравдагч этгээдүүд нь энэхүү Дүрмийг хүлээн авсан бөгөөд дараахыг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- энэхүү Дүрэмд заасан шаардлагуудыг дагаж мөрдөх;
- PwC-аас Гуравдагч этгээдэд хийх хөндлөнгийн дүн шинжилгээнд зориулж бүрэн, үнэн зөв мэдээлэл өгөх;
- үйл ажиллагаа явуулж буй улс орны холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.

[pwc.com/thirdpartycodeofconduct](https://www.pwc.com/thirdpartycodeofconduct)